

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

1 Агуулга

1	Агуулга	1
1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	4
2.1.	Оршил	4
2.2	. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин	5
2.4.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл	9
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
НББ	Нягтлан бодох бүртгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.02.25 № 06/335
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрчим хүчний яамны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Эрчим хүчний яамны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эрчим хүчний яамны 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Эрчим хүчний яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрчим хүчний яамны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрчим хүчний яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 1 дүгээр сарын 28-ны өдрөөс 2019 оны 2 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Л.Хонгорзул, аудитор Б.Даваабаатар нар хариуцаж хэрэгжүүлэв.

Эрчим хүчний яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Эрчим хүчний яамны 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн В/350 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт хуулийн хугацаанд ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Эрчим хүчний яамны талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Эрчим хүчний яамны зорилго нь Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн өсөлтийг хангахуйц эрчим хүчний бодлогыг хэрэгжүүлж, хүний эрүүл, аюулгүй, тав тухтай орчинд амьдрах болон үйлдвэрлэл, үйлчилгээний найдвартай, тогтвортой нөхцлийг хангах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Эрчим хүчний яам үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Эрчим хүчний салбарын аюулгүй, найдвартай ажиллагаа, үр ашигтай байдлыг хангах;
2. Эрчим хүчний шинэ эх үүсвэр бий болгох, бүс нутгийн шугам сүлжээ байгуулах;
3. Эрчим хүчний хангамжийн тасралтгүй, найдвартай, аюулгүй байдлыг хангах;
4. Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх;
5. Эрчим хүчний эх үүсвэрүүдийн түлшний баланс гаргах замаар нүүрсний уурхайнуудын хүчин чадлыг өргөжүүлэх;

6. Эрчим хүчний нүүрсний болон шинэ, хийн түлшний технологийг хөгжүүлэх, инновацийг дэмжих;
7. Салбарын эдийн засгийн үр ашиг, санхүүгийн чадавхийг сайжруулах, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, олон улсын хөгжлийн чиг хандлагатай уялдуулан хамтын ажиллагааг өргөжүүлэх;
8. Салбарын удирдлага болон тогтолцоог боловсронгуй болгох, тус салбарт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх замаар салбарын өрсөлдөх чадавхийг дээшлүүлэх;
9. Эрчим хүч, түлш (эрчим хүчний нүүрс)-ний салбарт шинжлэх ухаан, технологи, эрчим хүчний балансын судалгаа, стандарт, норм, нормативын баримт бичиг, техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийж, эрчим хүчний хэмнэлттэй, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх явдал байна.

Эрчим хүчний яам үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Эрчим хүчний яамны удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Эрчим хүчний яамны хөдөлмөрийн дотоод журам

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Төсөл, хөтөлбөрүүд Сангийн яаманд харъяалагдах болсон, Засгийн газрын тогтоолоор Төрийн өмчит хувьцаат компанийн статус өөрчлөгдсөн.

2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого журамтай нийцсэн байна.

Эрчим хүчний яамны санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн

мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Эрчим хүчний яам санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Аккоулс” програм хангамж ашигладаг байна.

Эрчим хүчний яамны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Үр нөлөөгүй” гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Эрчим хүчний яамны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 3 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 0.2 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нийт хөрөнгийн дүнгээс тооцоход их байгаатай холбоотой юм.

Эрчим хүчний яамны 2018 оны нийт зардал 19,812,708.5 мянган төгрөг бөгөөд түүний 0.2 хувь болох 39,624.07 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 11 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 1 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэнээс гадна 4 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	3,711.4	
2	Албан шаардлага өгсөн	1	1,843.7	
	Дүн	4	5,555.1	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Эрчим хүчний яам "Эрдэнэбүрэн усан цахилгаан станц" төслөөс 804.0 мянга, "Дулааны цахилгаан станц-4" төслөөс 459.7 мянга, нийт 1,263.7 мянган төгрөгийг шатахууны зардалд зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.7-д *"Төрөөс хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, хөтөлбөр, арга хэмжээ, татвар ногдуулалт, эсхүл хөнгөлөлт, баталгаа, зээл, өр төлбөр, санхүүгийн үйл ажиллагаа, болзошгүй өр төлбөр, тэдгээрийн үр дүн нь өнөө болон ирээдүй үеийн хооронд тэгш бус байдал үүсгэхгүй байх"*, 41 дүгээр зүйлийн 41.2.2-д *"Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах"* гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн холбогдох заалтуудыг баримтлан хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага өгөв.

2. Дотоод албан томилолтоор Өмнөговь аймагт ажилласан Д.Мөнхжаргал 290.0 мянга, Х.Бекболат 290.0 мянга, нийт 580.0 мянган төгрөгийг анхан шатны бүрдэл дутуу баримтаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т *"Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно"*, 13.7-д *"Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"*, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 142 дугаар тушаалаар батлагдсан Хөдөлмөрийн дотоод журмын 4 дүгээр зүйлийн 4.2.11-т *"Гадаад дотоод томилолтоор ажилласан тохиолдолд ирснээс хойш ажлын 5 хоногт багтаан илтгэх хуудсыг бичиж, холбогдох нэгжийн удирдлага, төрийн нарийн бичгийн даргад танилцуулах үүрэгтэй"* гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн дотоод журмын холбогдох заалтуудыг баримтлан хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага өгөв.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Эрчим хүчний яамны урсгал зардалд батлагддаг татаасын санхүүжилт, Төрийн өмчит компаниудад хуваарилсан зардлын гүйцэтгэлийг болон НӨАТ-ын талаар Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар түүвэрт хамруулан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Эрчим хүчний яам чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 5 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 19,948,004.6 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 19,423,816.2 мянган төгрөг буюу 99 хувьтай байгаа нь орон тооноос хамаарч цалингийн зардлыг 74,188.3 мянган төгрөгөөр хэмнэснээс шалтгаалжээ.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Эрчим хүчний яам Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Эрчим хүчний яам Шилэн дансны тухай хуулийн дагуу тус байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn/Эрчим хүчний яам цахим хуудсанд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар 2018 оны төсвийн хуваарь, түүний гүйцэтгэл, санхүүгийн тайлан, дараа жилийн төсвийн төсөл, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ зэрэг мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 4 зөвлөмж өгснөөс 100 хувь хэрэгжүүлж биелэлтийг 2018 оны 07 дугаар сарын 01-ний өдөр Үндэсний аудитын газарт хүргүүлсэн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Эрчим хүчний яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Эрчим хүчний яамны 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Эрчим хүчний яам нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. “Зардлын данстай холбоотой асуудал”

3.1.1. Илрүүлэлт

Яамны урсгал зардлаас "Эрчим хүчний системийн үр ашиг" төслийн автомашинд 4ш дугуй худалдан авахад 1,360.0 мянган төгрөг зарцуулсан, төслийн данснаас 1,116.5 мянган төгрөгийг буцаан яамны автомашины засварт шилжүүлж, үлдсэн 243.5 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах"*, 6.4.2-д *"Төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх"* гэсэн заалтуудыг тус тус нийцэхгүй байна.

3.1.2. Эрсдэл

Төсвийн хөрөнгө зориулалт бусаар зарцуулагдах

3.1.3. Өгсөн зөвлөмж

Дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

3.2. “Авлага, өглөгийн данстай холбоотой асуудал”

3.2.1. Илрүүлэлт

Тайлант оны эцэст авлага 1,479.1 мянга, өглөг 198.6 мянган төгрөгөөр өссөн, авлагын хувьд нийгмийн даатгалын шимтгэлээс хөнгөлөлт үзүүлсэн, өглөгийн хувьд яамны урсгал хариуцсан санхүүгийн мэргэжилтэн жижиг мөнгөн сангийн гүйлгээг төрийн сангийн программд шивээгүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дэх хэсэгт *“Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”* гэж заалттай нийцэхгүй байна.

3.2.2. Эрсдэл

Төсөв захирагч Төсвийн тухай хуулиар хүлээсэн үүргийг биелүүлэхгүй байх

3.2.3. Өгсөн зөвлөмж

Дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх Төсвийн тухай хуулийг дагаж мөрдөж, авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах талаар зөвлөмж өгөв.

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

3.3. “Зардлын данстай холбоотой асуудал”

3.3.1. Илрүүлэлт

Яамны байрны урсгал засварт 840.0 мянга, автомашины засвар үйлчилгээнд 703.5 мянган төгрөг, нийт 1,543.5 мянган төгрөгийг хувь хүний дансанд шилжүүлсэн бөгөөд ХХОАТ-т 154.4 мянган төгрөг суутган тооцоогүй байна.

Энэ нь ХХОАТ-ын тухай хуулийн 26.1.2-т *“Энэ хуулийн 11.1.1-д заасан албан татварыг сар бүрийн эцэст ногдуулж, мөн хуулийн 24.1-д заасан хөнгөлөлтийг хасч, холбогдох төсөвт шилжүүлэх”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”* гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

3.3.2. Эрсдэл

Төсөв захирагч Төсвийн тухай хуулиар хүлээсэн үүргийг биелүүлэхгүй байх

3.3.3. Өгсөн зөвлөмж

Дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, Төсвийн тухай хуулийг дагаж мөрдөн, авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах талаар зөвлөмж өгөв.

3.3.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эхний үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	27,587,151.95	26,940,253.20
2	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	0.00	198,667.00
3	Кассад байгаа бэлэн мөнгө	-	198,667.00
4	Төгрөг	-	198,667.00
27	АВЛАГА	-	1,479,170.00
28	Ажиллагсадтай холбогдсон авлага	-	1,479,170.00
48	УРЬДЧИЛГАА	(0.00)	(0.00)
54	Урьдчилж гарсан зардал	(0.00)	(0.00)
60	БАРАА МАТЕРИАЛ	27,587,151.95	25,262,416.20
66	Хангамжийн материал	27,587,151.95	25,262,416.20
67	Бичиг хэргийн материал	5,146,489.40	4,291,200.00
68	Аж ахуйн материал	897,035.00	765,925.00
69	Сэлбэг хэрэгсэл	1,472,436.35	2,753,100.00
73	Бусад хангамжийн материал	20,071,191.20	17,452,191.20
86	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	45,574,532,915.66	9,982,943,926.52
106	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	45,574,532,915.66	9,982,943,926.52
108	Биет хөрөнгө	45,574,532,915.66	9,791,189,566.52
109	Барилга, байгууламж	1,580,464,440.10	1,892,610,585.10
110	Хуримтлагдсан элэгдэл	(1,033,547,161.54)	(178,098,547.90)
111	Авто тээврийн хэрэгсэл	562,995,950.00	562,995,950.00
112	Хуримтлагдсан элэгдэл	(352,465,822.67)	(418,193,619.18)
113	Машин, тоног төхөөрөмж	454,844,319.80	503,554,009.80
114	Хуримтлагдсан элэгдэл	(356,538,747.48)	(382,674,506.26)
115	Тавилга, аж ахуйн эд хогшил	333,363,909.33	345,257,209.33
116	Хуримтлагдсан элэгдэл	(201,665,371.88)	(228,030,567.90)
122	Бусад үндсэн хөрөнгө	-	3,361,499.00
123	Хуримтлагдсан элэгдэл	-	(129,645.47)
124	Дуусаагүй барилга, байгууламж	44,587,081,400.00	7,690,537,200.00
126	Биет бус хөрөнгө	-	191,754,360.00
127	Программ хангамж	4,800,000.00	4,800,000.00
128	Хасагдуулга	(4,800,000.00)	(4,800,000.00)
129	Бусад биет бус хөрөнгө	-	191,754,360.00
137	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	45,602,120,067.61	10,009,884,179.72
138	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	15,519,447.50	10,409,547.30
139	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	(0.00)	198,667.00
164	Өглөг	(0.00)	198,667.00
170	Бусад өглөг	(0.00)	198,667.00
172	Хувь хүмүст төлөх өглөг	-	198,667.00
183	УРТ ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨР	15,519,447.50	10,210,880.30
193	Урт хугацаат зээл	15,519,447.50	10,210,880.30
194	Төгрөг	15,519,447.50	10,210,880.30
198	Төрийн өмчид аж ахуй нэгжүүдийн зээл	15,519,447.50	10,210,880.30
214	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	45,586,600,620.11	9,999,474,632.42
215	Засгийн газрын хувь оролцоо	45,586,600,620.11	9,999,474,632.42
216	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	45,342,950,329.68	8,638,160,489.68
217	Өмч: -Төрийн өмч	45,342,950,329.68	8,638,160,489.68
223	Хуримтлагдсан үр дүн	243,650,290.43	171,326,253.65
224	Өмнөх үеийн үр дүн	243,650,290.43	243,650,290.43
225	Тайлант үеийн үр дүн	-	(72,324,036.78)
227	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-	1,189,987,889.09
231	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	45,602,120,067.61	10,009,884,179.72

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	15,767,482,926.00	19,739,708,568.66
76	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	64,856,026.00	31,775,592.66
77	Нийтлэг татварын бус орлого	64,856,026.00	31,775,592.66
81	Төсөвт байгууллагын өөрийн орлого	59,508,465.00	25,121,626.66
83	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	41,655,266.00	-
86	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	17,853,199.00	25,121,626.66
92	Бусад орлого	5,347,561.00	6,653,966.00
111	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	15,702,626,900.00	19,707,932,976.00
112	Улсын төвлөрсөн төсвөөс	15,702,626,900.00	19,498,004,600.00
113	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	15,137,036,900.00	19,498,004,600.00
114	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	565,590,000.00	-
122	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	209,928,376.00
125	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	-	209,928,376.00
147	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	14,997,538,600.83	19,812,029,309.11
148	УРСГАЛ ЗАРДАЛ	14,997,538,600.83	19,812,029,309.11
149	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,367,649,015.83	2,545,370,495.81
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,293,614,545.00	1,125,436,174.00
151	Цалин	1,293,614,545.00	1,083,436,842.00
152	Нэмэгдэл цалин	-	41,999,332.00
157	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	142,545,801.00	134,436,085.88
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	91,070,025.00	90,904,381.92
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	12,983,522.00	11,447,126.49
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	10,342,658.00	8,029,822.00
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	2,559,054.00	2,186,833.49
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	25,590,542.00	21,867,921.98
164	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,043,918.00	77,885,035.80
165	Гэрэл цахилгааны зардал	35,136,870.00	50,623,603.00
166	Түлш, халаалтын зардал	15,546,045.00	21,027,432.80
167	Цэвэр, бохир усны зардал	2,361,003.00	6,234,000.00
170	Хангамж, бараа материалын зардал	42,181,506.82	53,077,325.40
171	Бичиг хэргийн материал	10,906,325.00	14,308,871.40
172	Гээвэр, шатахууны зардал	7,124,970.00	7,640,300.00
173	Шуудан холбоо интернэтийн төлбөр	14,581,899.72	22,159,509.00
175	Хог хаягдал устгах, цэвэрлэх	715,000.00	1,446,800.00
176	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	5,690,340.10	2,061,476.00
178	Бараа материал акталсны зардал	3,162,972.00	5,460,369.00
181	Нормативд зардал	2,272,000.00	975,380.00
184	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,272,000.00	975,380.00
185	Эд хогшил, урсгал засварын зардал	12,568,792.00	24,705,742.35
188	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	-	695,996.00
189	Урсгал засвар	12,568,792.00	24,009,746.35
190	Томилот, зочны зардал	17,673,815.00	35,611,133.00

Эрчим хүчний яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

192	Дотоод томилолтын зардал	17,673,815.00	35,611,133.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	17,166,123.00	22,291,483.00
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	53,940.00	-
198	Тээврийн хэрэгслийн татвар	1,260,825.00	5,278,410.00
200	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	8,749,820.00	10,470,910.00
203	Улсын мэдээллийн маягтын зардал	7,101,538.00	6,542,163.00
209	Бараа үйлчилгээний бусад зардал	786,582,515.01	1,070,952,136.38
210	Бараа үйлчилгээний бусад зардал	657,855,002.00	934,201,578.82
212	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	128,727,513.01	136,750,557.56
219	ТАТААС	12,613,300,000.00	17,149,933,300.00
220	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	12,613,300,000.00	17,149,933,300.00
221	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	12,613,300,000.00	17,149,933,300.00
224	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,589,585.00	116,725,513.30
225	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,288,339.00	4,400,000.00
227	Засгийн газрын гадаад шилжүүлэг	1,288,339.00	4,400,000.00
228	Бусад урсгал шилжүүлэг	15,301,246.00	38,335,879.00
231	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	15,301,246.00	38,335,879.00
247	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт	-	73,989,634.30
250	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	73,989,634.30
268	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	769,944,325.17	(72,320,740.45)
276	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	3,296.33
283	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	-	3,296.33
287	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	-	(3,296.33)
288	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	769,944,325.17	(72,324,036.78)

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-3А

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	18,415,857,017.00	19,707,932,976.00
77	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,713,230,117.00	-
78	Нийтлэг татварын бус орлого	2,713,230,117.00	-
82	Төсөвт байгууллагын өөрийн орлого	10,682,156.00	-
84	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,682,156.00	-
92	Бусад орлого	2,702,547,961.00	-
110	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	15,702,626,900.00	19,707,932,976.00
111	Улсын төвлөрсөн төсвөөс	15,702,626,900.00	19,498,004,600.00
112	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	15,137,036,900.00	19,498,004,600.00
113	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	565,590,000.00	-
121	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	209,928,376.00
124	ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	-	209,928,376.00
147	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	14,860,505,280.12	19,672,936,920.00
148	УРСГАЛ ЗАРДАЛ	14,860,505,280.12	19,672,936,920.00
149	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,230,852,924.72	2,406,883,697.70
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	822,950,626.00	1,124,250,907.00
151	Үндсэн цалин	573,990,645.00	843,483,589.00
152	Нэмэгдэл	189,214,381.00	201,107,018.00
153	Унаа хоолны хөнгөлөлт	59,745,600.00	79,660,300.00
157	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,512,800.00	136,372,900.00
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	50,945,500.00	92,420,461.00
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	10,189,100.00	9,859,239.00
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	-	9,091,500.00
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	-	2,272,900.00
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	20,378,200.00	22,728,800.00
164	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	53,716,817.00	83,193,603.00
165	Гэрэл цахилгааны зардал	35,136,870.00	50,623,603.00
166	Түлш, халаалтын зардал	16,218,944.00	26,336,000.00
167	Цэвэр, бохир усны зардал	2,361,003.00	6,234,000.00
170	Хангамж, бараа материалын зардал	31,699,813.72	48,671,839.00
171	Бичиг хэрэг	7,935,180.00	13,092,623.00
172	Тээвэр, шатахуун	5,730,300.00	7,640,300.00
173	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,581,899.72	22,159,509.00
175	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	715,000.00	1,446,800.00
176	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,737,434.00	4,332,607.00
181	Нормативд зардал	271,000.00	1,355,885.00
184	Нормын хувцас, зөөлөн эдлэл	271,000.00	1,355,885.00
185	Эд хогшил, урсгал засварын зардал	16,684,497.00	24,686,852.00
188	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	-	1,074,096.00
189	Урсгал засвар	16,684,497.00	23,612,756.00
190	Томилот, зочны зардал	18,073,115.00	35,525,266.00

Эрчим хүчний яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

192	Дотоод албан томилолт	18,073,115.00	35,525,266.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,329,323.00	23,960,210.00
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	53,940.00	-
198	Тээврийн хэрэгслийн татвар	1,260,825.00	4,712,400.00
200	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,731,020.00	9,347,810.00
203	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	8,283,538.00	9,900,000.00
208	Бараа үйлчилгээний бусад зардал	1,186,614,933.00	928,866,235.70
209	Бараа үйлчилгээний бусад зардал	1,186,614,933.00	928,866,235.70
216	ТАТААС	12,613,300,000.00	17,149,933,300.00
217	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	12,613,300,000.00	17,149,933,300.00
218	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	12,613,300,000.00	17,149,933,300.00
221	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,352,355.40	116,119,922.30
222	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,288,339.00	4,400,000.00
224	Засгийн газрын гадаад шилжүүлэг	1,288,339.00	4,400,000.00
225	Бусад урсгал шилжүүлэг	15,064,016.40	37,730,288.00
228	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	15,064,016.40	37,730,288.00
244	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	73,989,634.30
247	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	73,989,634.30
250	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	3,555,351,736.88	34,996,056.00
251	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
252	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	29,100,000,000.00	-
254	Улсын төсвөөс олгосон зээл	29,100,000,000.00	-
261	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,489,700.00	34,797,389.00
262	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,489,700.00	34,797,389.00
263	Дотоод эх үүсвэрээр	2,489,700.00	34,797,389.00
275	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,489,700.00	34,797,389.00
278	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	29,097,510,300.00	(34,797,389.00)
279	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
288	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙН ХАССАН ЗЭЭЛ	29,100,000,000.00	-
289	Эргэж төлөгдөх зээл	29,100,000,000.00	-
302	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(29,100,000,000.00)	-
303	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	3,552,862,036.88	198,667.00
304	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
305	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		198,667.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2	2017 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	5,342,950,329.68		280,854,591.64	5,623,804,921.32
4	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,342,950,329.68		280,854,591.64	5,623,804,921.32
8	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/			222,592,725.02	222,592,725.02
9	2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	5,342,950,329.68		243,650,290.43	45,586,600,620.11
10	2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	5,342,950,329.68		243,650,290.43	5,586,600,620.11
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,342,950,329.68		243,650,290.43	5,586,600,620.11
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		1,189,987,889.09		1,189,987,889.09
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	- 36,704,789,840.00			- 36,704,789,840.00
17	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/			- 72,324,036.78	- 72,324,036.78
18	2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	8,638,160,489.68	1,189,987,889.09	171,326,253.65	9,999,474,632.42

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Тайлант оны			
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	19,498,004,600.00	19,423,816,298.70	74,188,301.30	99.62
УРСГАЛ ЗАРДАЛ	19,498,004,600.00	19,423,816,298.70	74,188,301.30	99.62
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,305,604,600.00	2,231,752,710.70	73,851,889.30	96.80
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,136,440,900.00	1,124,250,907.00	12,189,993.00	98.93
Үндсэн цалин	846,351,000.00	843,483,589.00	2,867,411.00	99.66
Нэмэгдэл	210,429,600.00	201,107,018.00	9,322,582.00	95.57
Унаа хоолны хөнгөлөлт	79,660,300.00	79,660,300.00	-	100.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	136,372,900.00	136,372,900.00	-	100.00
Тэтгэврийн даатгал	90,915,300.00	92,420,461.00	- 1,505,161.00	101.66
Тэтгэмжийн даатгал	11,364,400.00	9,859,239.00	1,505,161.00	86.76
ҮОМШӨ-ний даатгал	9,091,500.00	9,091,500.00	-	100.00
Ажилгүйдлийн даатгал	2,272,900.00	2,272,900.00	-	100.00
Эрүүл мэндийн даатгал	22,728,800.00	22,728,800.00	-	100.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	83,706,600.00	83,193,603.00	512,997.00	99.39
Гэрэл, цахилгаан	51,136,600.00	50,623,603.00	512,997.00	99.00
Түлш, халаалт	26,336,000.00	26,336,000.00	-	100.00
Цэвэр, бохир ус	6,234,000.00	6,234,000.00	-	100.00
Хангамж, бараа материалын зардал	50,921,600.00	50,134,784.00	786,816.00	98.45
Бичиг хэрэг	13,338,100.00	13,338,100.00	-	100.00
Тээвэр, шатахуун	7,640,300.00	7,640,300.00	-	100.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	22,988,400.00	22,217,488.00	770,912.00	96.65
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,446,800.00	1,446,800.00	-	100.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,508,000.00	5,492,096.00	15,904.00	99.71
Нормативд зардал	2,776,900.00	1,355,885.00	1,421,015.00	48.83
Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,776,900.00	1,355,885.00	1,421,015.00	48.83
Эд хогшил, урсгал засварын зардал	57,163,400.00	57,163,296.00	104.00	100.00
Багаж, техник, хэрэгсэл	32,000,000.00	31,825,444.00	174,556.00	99.45
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,074,100.00	1,074,096.00	4.00	100.00
Урсгал засвар	24,089,300.00	24,263,756.00	- 174,456.00	100.72
Томилолт, зочны зардал	35,579,300.00	35,525,266.00	54,034.00	99.85
Дотоод албан томилолт	35,579,300.00	35,525,266.00	54,034.00	99.85
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,843,000.00	24,818,210.00	24,790.00	99.90
Тээврийн хэрэгслийн татвар	4,712,400.00	4,712,400.00	-	100.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,230,600.00	10,205,810.00	24,790.00	99.76
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	9,900,000.00	9,900,000.00	-	100.00
Бараа үйлчилгээний бусад зардал	777,800,000.00	718,937,859.70	58,862,140.30	92.43
Бараа үйлчилгээний бусад зардал	777,800,000.00	718,937,859.70	58,862,140.30	92.43
ТАТААС	17,150,000,000.00	17,149,933,300.00	66,700.00	100.00
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	17,150,000,000.00	17,149,933,300.00	66,700.00	100.00

Эрчим хүчний яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төрийн өмчит байгууллагад олгох татаас	17,150,000,000.00	17,149,933,300.00	66,700.00	100.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,400,000.00	42,130,288.00	269,712.00	99.36
Засгийн газрын урсгал шилжүүлэг	4,400,000.00	4,400,000.00	-	100.00
Засгийн газрын гадаад шилжүүлэг	4,400,000.00	4,400,000.00	-	100.00
Бусад урсгал шилжүүлэг	38,000,000.00	37,730,288.00	269,712.00	99.29
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	38,000,000.00	37,730,288.00	269,712.00	99.29
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	19,498,004,600.00	19,424,014,965.70	73,989,634.30	99.62
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	19,498,004,600.00	19,424,014,965.70	73,989,634.30	99.62
Улсын төсвөөс санхүүжих	19,498,004,600.00	19,424,014,965.70	73,989,634.30	99.62
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	198,667.00	- 198,667.00	
АЖИЛЛАГСДЫН ТОО	95	88	7.00	92.63
Удирдах ажилтан	13	13	-	100.00
Гүйцэтгэх ажилтан	68	61	7.00	89.71
Үйлчлэх ажилтан	14	14	-	100.00

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2018 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:	САГ-2019/33/СТА-ТШЗ
---------------	----------------	---------------------	------------------------------------	---------------------	---------------------

Шалгагдсан байгууллагын нэр:	Эрчим хүчний яам	Мянган төгрөгөөр
-------------------------------------	-------------------------	-------------------------

А	З	4.0	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл		Алдаа зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтан	
			Нэр	Албан тушаал	Овог нэр	
А	З	4.0	5	8	9	
	Яамны урсгал зардлаас "Эрчим хүчний системийн үр ашиг" төслийн автомашинд 4ш дугуй худалдан авахад 1,360.0 мянган төгрөг зарцуулсан, төслийн данснаас 1,116.5 мянган төгрөгийг буцаан яамны автомашины засварт шилжүүлж, үлдсэн 243.5 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна	243.5	Зөвлөмж өгөх	Төрийн нарийн бичгийн дарга Санхүү хэлтсийн дарга Ерөнхий нягтлан бодогч	З.Мэндсайхан Б.Баясгалан П.Энхцэлмэг	
	Тайлант оны эцэст авлага 1,479.1 мянган, өглөг 198.6 мянган төгрөгөөр өссөн байна	1,677.7	Зөвлөмж өгөх	Төрийн нарийн бичгийн дарга Санхүү хэлтсийн дарга Ерөнхий нягтлан бодогч	З.Мэндсайхан Б.Баясгалан П.Энхцэлмэг	
2	Яамны байрны урсгал засварт 840.0 мянга, автомашины засвар үйлчилгээнд 703.5 мянган төгрөг, нийт 1,543.5 мянган төгрөгийг хувь хүний дансанд шилжүүлсэн бөгөөд ХХОАТ-т 154.4 мянган төгрөг суутган тооцоогүй нь байна	1,543.5	Зөвлөмж өгөх	Төрийн нарийн бичгийн дарга Санхүү хэлтсийн дарга Ерөнхий нягтлан бодогч	З.Мэндсайхан Б.Баясгалан П.Энхцэлмэг	
	1.Эрчим хүчний яам "Эрдэнэбүрэн усан цахилгаан станц" төслөөс 804.0 мянга, "Дулааны цахилгаан станц-4" төслөөс 459.7 мянга, нийт 1,263.7 мянган төгрөгийг шатахууны зардалд зарцуулсан байна 2.Дотоод албан томилолтоор Өмнөговь аймагт ажилласан Д.Мөнхжаргал 290.0 мянга, Х.Бекболат 290.0 мянга, нийт 580.0 мянган төгрөгийг анхан шатны бүрдэл дутуу баримтаар зарцуулсан байна					
Нийт дүн		5,308,4				

